# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 1 (286)

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:**

- *Үрийн тариалангийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2003 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2003 оны нэгдүгээр сарын 8 № 1 (286)

## Гарчиг

**Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

1. Үрийн тариалангийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-12-26-ны хууль) 1
2. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-12-27-ны хууль) 2

**Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

3. Төсөл буцаах тухай Дугаар 91 2
4. Төсөл буцаах тухай Дугаар 92 2
5. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх, орон нутгийн өмчийн зарим эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах тухай Дугаар 93 2
6. Төсөл буцаах тухай Дугаар 98 9

**Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

7. Цэрэнгийн Ерэнпилд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 194 9
8. Нямцэрэнгийн Мөнхбаярт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээх тухай Дугаар 195 9
9. Цэсрэнжавын Жанчивт Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 196 9
10. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 197 10

**Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

11. Төсөл дэмжих тухай Дугаар 223 15
12. Хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай Дугаар 224 15
13. Дуудлагын худалдаагаар худалдах төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн жагсаалт батлах тухай Дугаар 226 15

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

### ҮРИЙН ТАРИАЛАНГИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үрийн тариалангийн даатгалын тухай хуулийн 3.1 дэх хэсэгт дараахь заалтыг нэмсүгэй:

"3.1.2. "үр тариа" гэдэгт усалгаатай болон усалгаагүй нөхцөлд тариалсан буудай, арвай, хошуу будаа, сагаг будаа, хөх тариа, тритикале, бог будаа, эрдэнэ шиш, буурцагт ургамлыг."

**2 дугаар зүйл.** Үрийн тариалангийн даатгалын

тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "даатгуулагчид олгоно." гэсний дараа "Үрийн тариалангийн даатгалын хохирлыг тооцох аргачлалыг санхүүгийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална." гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Үрийн тариалангийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"4.1. Тухайн жилд усалгаагүй тариалсан үр тарианы нийт талбайн 20 хувь, усалгаатай тариалсан үр тариа болон баруун бүсийн усалгаагүй тариалсан үр тарианы нийт талбайн 10 хувийг үрийн тариалан гэж үзэж өмчийн хэлбэр үл харгалзан заавал даатгуулна."

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2002 оны 12 дугаар сарын 27-ны өдөр** — **Улаанбаатар хот**

### УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3. дахь хэсгийн "2003 оны 2 дугаар сарын 1-ний дотор" гэснийг "2006 оны 2 дугаар сарын 1-ний дотор" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2002 оны 12 дугаар сарын 19-ний өдөр** — **Дугаар 91** — **Улаанбаатар хот**

### Төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Ж.Наранцацралт, Л.Гүндалай нарын санаачилж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Мал бүхий иргэдийг албан татвараас чөлөөлөх тухай" хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2002 оны 12 дугаар сарын 19-ний өдөр** — **Дугаар 92** — **Улаанбаатар хот**

### Төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Ж.Наранцацралт, Л.Гүндалай нарын санаачилж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуулийг хүчингүй болгох тухай" хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2002 оны 12 дугаар сарын 20-ны өдөр** — **Дугаар 93** — **Улаанбаатар хот**

### Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх, орон нутгийн өмчийн зарим эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалтыг 1 дүгээр хавсралт ёсоор батласугай.

2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн 2 дугаар хавсралтад заасан эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авахыг Монгол Улсын Засгийн газарт зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 93 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

2002 он /мян.төг/

### 1.Архангай аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

| № | Сумын нэр | Эд хөрөнгийн нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Эрдэнэбулган | Газар доогуурх цэвэр, бохир усны шугам сүлжээ | 18'000.00 |
| | **ДҮН** | | **18'000.00** |

### 2.Баян-Өлгий аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

| № | Сумын нэр | Эд хөрөнгийн нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Өлгий | Татан буугдсан төрийн өмчийн төлөөлөгчийн албаны эд хөрөнгө | 6'676.50 |
| | **ДҮН** | | **6'676.50** |

### 3.Булган аймаг
Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

| № | Сумын нэр | Эд хөрөнгө нь шилжих байгууллагын нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Булган | Мал эмнэлгийн алба | 13'297.20 |
| | **ДҮН** | | 13'297.20 |

### 4.Говьсүмбэр аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

| № | Сумын нэр | Эд хөрөнгийн нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Сүмбэр | "Сүмбэр-2" хотхоны 75 айлын сууц /2 ширхэг/ | 8'000.00 |
| 2 | Сүмбэр | Стандартчилал хэмжил зүйн төвийн илүүдэлтэй хөрөнгө | 84.50 |
| | **ДҮН** | | **8'084.50** |

### 5.Дархан-Уул аймаг
Ногдол хувь, хувьцаа

| № | Сумын нэр | Ногдол хувь, хувьцаа нь шилжих байгууллагын нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Дархан | "Агротехсервис" ХК-ийн 4% | 3'558.50 |
| | **ДҮН** | | **3'558.50** |

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

| № | Сумын нэр | Шарын гол ХК-аас шилжих эд хөрөнгийн нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Шарын гол | Дулааны станц | 1'760'598.20 |
| 2 | Шарын гол | Үйлдвэрийн талбай | 273'902.50 |
| 3 | Шарын гол | Дулааны пункт | 161'175.70 |
| 4 | Шарын гол | Ус сувaг | 188'279.90 |
| 5 | Шарын гол | Дулааны станцын склад | 24'376.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | Шарын гол | Махны зоорь | 85'077.20 |
| 7 | Шарын гол | Ногооны зоорь | 2'248.50 |
| 8 | Шарын гол | Сэлбэг хэрэгсэл | 152'341.50 |
| | **ДҮН** | | **2'648'000.00** |

**6.Дорноговь аймаг**
**Байгууллагын эзэмшилд байгаа хөрөнгө**

| № | Сумын нэр | Эд хөрөнгө нь шилжих байгууллагын нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Сайншанд | Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэс | 16'672.50 |
| | **ДҮН** | | **16'672.50** |

**7.Дорнод аймаг**
**Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө**

| № | Сумын нэр | Эд хөрөнгө нь шилжих байгууллагын нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Чойбалсан | Цав ТӨҮГ | 5'100.00 |
| | **ДҮН** | | **5'100.00** |

**Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө**

| № | Сумын нэр | Эд хөрөнгийн нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Хэрлэн | 11 дүгээр цэцэрлэгийн эзэмшиж буй барилга/Дорнод бүсийн дулаан дамжуулах станц/ | 1'219.70 |
| 2 | Чойбалсан | Мардай тосгон дахь 45 айлын орон сууцны хоёр барилга | 1'000.00 |
| 3 | Чойбалсан | Молодёжная-8 орон сууцны барилга | 50.00 |
| 4 | Чойбалсан | Дружба-4 № 3 орон сууцны барилга | 25.00 |
| 5 | Чойбалсан | ЖБ-ийн 8 №1 орон сууцны барилга | 50.00 |
| 6 | Чойбалсан | Дружба-25-ийн №1, №2 орон сууцны барилга | 50.00 |
| | **ДҮН** | | **2'394.70** |

**8.Өвөрхангай аймаг**
**Дуусаагүй барилга, байгууламж**

| № | Сумын нэр | Барилга, байгууламжийн нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Арвайхээр | Цэвэр усны шугам, 100 куб метрийн усан сангийн байгууламж | 3'074.30 |
| | **ДҮН** | | **3'074.30** |

**9.Сүхбаатар аймаг**
**Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө**

| № | Сумын нэр | Эд хөрөнгийн нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Баруун-Урт | Сум дундын шүүхийн барилга | 420.00 |
| | **ДҮН** | | **420.00** |

10.Сэлэнгэ аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

| № | Сумын нэр | Эд хөрөнгийн нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Ерөө | Ерөө хониньы туршилт сорилын төв /214 мал, бусад хөрөнгө/ | 8'319.90 |
| | **ДҮН** | | **8'319.90** |

Дуусаагүй барилга

| № | Сумын нэр | Барилгын нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Ерөө | Хүн эмнэлгийн дуусаагүй барилгын цогцолбор | 18'000.00 |
| | **ДҮН** | | **18'000.00** |

11.Төв аймаг
Байгууллагын эзэмшилд байгаа хөрөнгө

| № | Сумын нэр | Эд хөрөнгө нь шилжих байгууллагын нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Зуунмод | Хүнс, хөдөө аж ахуйн газар | 70'672.39 |
| | **ДҮН** | | **70'672.39** |

12.Увс аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

| № | Сумын нэр | Эд хөрөнгийн нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Баруунтуруун | Ахуй үйлчилгээний зориулалттай 2 давхар барилга /Улсын нөөцийн газраас шилжих/ | 9'000.00 |
| | **ДҮН** | | **9'000.00** |

13.Ховд аймаг
Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

| № | Сумын нэр | Байгууллагын нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Жаргалант | "Бадамлах дөл" ТӨҮГ | 771'491.50 |
| | **ДҮН** | | **771'491.50** |

14.Хөвсгөл аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

| № | Сумын нэр | Эд хөрөнгийн нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Мөрөн | УАЗ-469 маркийн автомашин /УБЗ-01-70/ | 3'409.50 |
| | **ДҮН** | | **3'409.50** |

15.Хэнтий аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

| № | Сумын нэр | Эд хөрөнгийн нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Хэрлэн | 120 хүүхдийн яслийн барилга | 77'750.00 |
| | **ДҮН** | | **77'750.00** |

16.Улаанбаатар хот
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

| № | Дүүргийн нэр | Эд хөрөнгийн нэр | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Сонгинохайрхан | Хүүхдийн клиник сувилал №41-ийн эзэмшиж буй барилга /ДЦС-II-ийн өмчлөлийн/ | 47'100.00 |
| | **ДҮН** | | **47'100.00** |
| | **НИЙТ ДҮН** | | **3'731'021.49** |

*Монгол Улсын Их Хурлын 2002 оны 93 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт*

## АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРИЙГ ҮНДЭСЛЭН ОРОН НУТГИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВАХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

2002 он /мян.төг/

### 1.Архангай аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Эрдэнэбулган | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв | 100 | 62'320.60 |
| | Дүн | | | **62'320.60** |

### 2.Баян-Өлгий аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Өлгий | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв | 100 | 16'626.60 |
| | Дүн | | | **16'626.60** |

### 3.Булган аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Булган | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв | 100 | 69'559.40 |
| 2 | Булган | Эрдэнэсуврага ХК | 81 | 336'730.80 |
| 3 | Сэлэнгэ | Ингэттолгой ХК-ийн | 7 | 63'100.00 |
| | ДҮН | | | **469'390.20** |

### 4.Говь-Алтай аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Есөнбулаг | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв | 100 | 306'153.20 |
| | Дүн | | | **306'153.20** |

### 5.Дархан-Уул аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Дархан | Зам засвар арчлалтын компани | 100 | 116'376.10 |
| 2 | Дархан | Аюулаас хамгаалах тэжээлийн Дархан төв | 100 | 6378.77 |
| | ДҮН | | | **122.754.87** |

### 6.Дорноговь аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Сайншанд | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв | 100 | 20'343.70 |
| | Дүн | | | **20'343.70** |

7.Дорнод аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Хэрлэн | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв | 100 | 33'080.00 |
| 2 | Хэрлэн | Зүүн бүсийн эмчилгээ-оношлогооны төв | 100 | 2'657'044.00 |
| | ДҮН | | | **2'690'124.00** |

8.Завхан аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Улиастай | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв | 100 | 22'180.20 |
| 2 | Булнай | Аюулаас хамгаалах тэжээлийн фонд | 100 | 1'693.62 |
| 3 | Завханмандал | Тэжээлийн цэг | 100 | 1'985.78 |
| | ДҮН | | | **25'859.60** |

9.Орхон аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Орхон | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв | 100 | 46'175.30 |
| 2 | Орхон | МУИС-ийн салбар сургуу-лийн түрээслэж буй 3 давхар барилга | 100 | 1'693.62 |
| | ДҮН | | | **47'868.92** |

10.Өвөрхангай аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Арвайхээр | Хангайн бүсийн эмчилгээ-оношлогоо төв | 100 | 1'116'690.00 |
| 2 | Сант | Тэжээлийн цэг | 100 | 2'985.40 |
| | ДҮН | | | **1'119'675.40** |

11.Сүхбаатар аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Түмэнцогт | Тэжээлийн цэгийн үндсэн хөрөнгө | 100 | 1'921.00 |
| | Дүн | | | **1'921.00** |

12.Сэлэнгэ аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Сүхбаатар | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв | 100 | 77'061.60 |
| | Дүн | | | **77'061.60** |

13.Төв аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Бүрэн | Булангаагийн өвс тэжээлийн цэг | 100 | 4'158.00 |
| | Дүн | | | **4'158.00** |

14.Увс аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Улаангом | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв | 100 | 373'415.30 |
| 2 | Өмнөговь | Тэжээлийн нөөцийн цэг | 100 | 38'639.45 |
| | ДҮН | | | 412'054.75 |

15.Ховд аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Жаргалант | Баруун бүсийн эмчилгээ-оношлогоо төв | 100 | 592'933.90 |
| 2 | Жаргалант | Эрчим хүчний үйлдвэр | 100 | 305'088.40 |
| 3 | Булган | Тэжээлийн цэгийн үндсэн хөрөнгө | 100 | 14'840.60 |
| | ДҮН | | | 912'862.90 |

16.Хөвсгөл аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Мөрөн | Тэжээлийн цэгийн үндсэн хөрөнгө /цэрэг татлагын барилга/ | 100 | 3'170.00 |
| | Дүн | | | 3'170.00 |

17.Хэнтий аймаг

| № | Сум, дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Хэрлэн | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв | 100 | 116'367.22 |
| 2 | Баянмөнх | Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам | 100 | 378.20 |
| 3 | Дархан | Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам | 100 | 471.60 |
| 4 | Дэлгэрхаан | Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам | 100 | 352.30 |
| 5 | Өмнөдэлгэр | Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам | 100 | 511.10 |
| 6 | Батноров | Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам | 100 | 572.70 |
| 7 | Гурванбаян | Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам | 100 | 1'073.60 |
| | Дүн | | | 119'726.72 |

18.Улаанбаатар хот

| № | Дүүргийн нэр | Байгууллагын нэр | Орон нутгийн өмчийн хувь | Нийт хөрөнгийн дүн /2001 он/ |
|---|---|---|---|---|
| 1 | Сонгинохайрхан | Эрчим хүчний сургалтын төв | 100 | 159'470.90 |
| | ДҮН | | | 159.470.90 |
| | НИЙТДҮН | | | 6'571'542.96 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 98 | Улаанбаатар хот

### Төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газраас 2002 оны 10 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн "Бүсийн төв хот, бүсийн тулгуур төв хот, бүлэг суурингийн тогтолцоог тодорхойлох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн "Нийт бүлэг суурингийн тогтолцоо" гэсэн 2 дугаар хавсралт, "Бүлэг суурингийн төвүүдийн тогтолцоо" гэсэн 3 дугаар хавсралт, "Бүлэг суурингийн тогтолцоонд хамрагдах сум суурин газрууд" гэсэн 4 дүгээр хавсралтыг аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн үндсэн дээр дахин хянаж, Улсын Их Хуралд өргөн барих нь зүйтэй гэж үзэж хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 12 дугаар сарын 18-ны өдөр | Дугаар 194 | Улаанбаатар хот

### Цэрэнгийн Ерэнпилд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

"Эрдэнэт" үйлдвэрт олон жил үр бүтээлтэй ажиллаж, мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшин, хөдөлмөр хөнгөвчлөх, материал түүхий эд хэмнэх оновчтой шийдлүүд гарган үйлдвэрлэлд нэвтрүүлж, үйлдвэрлэлийн даалгаврыг тогтмол давуулан биелүүлж байгаа хөдөлмөр бүтээлийг нь үнэлж Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн баяжуулах фабрикийн баяжуулагч Цэрэнгийн Ерэнпилд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 12 дугаар сарын 18-ны өдөр | Дугаар 195 | Улаанбаатар хот

### Нямцэрэнгийн Мөнхбаярт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээх тухай

Багануурын нүүрсний уурхайд экскаваторын туслах машинч, машинч-бригадын даргаар олон жил үр бүтээлтэй ажиллаж хариуцсан машин механизмын засвар үйлчилгээг чанартай хийж, техник ашиглалтын хугацааг уртасган, нүүрс олборлох даалгаврыг тогтмол давуулан биелүүлж байгаа хөдөлмөр бүтээлийг нь үнэлж нийслэлийн "Багануур" ХК-ийн экскаваторын машинч Нямцэрэнгийн Мөнхбаярт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 12 дугаар сарын 18-ны өдөр | Дугаар 196 | Улаанбаатар хот

### Цэсрэнжавын Жанчивт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Шинжлэх ухааны байгууллагад эрдэм шинжилгээний ажилтан, хүрээлэнгийн захирлаар олон жил санаачлага, үр бүтээлтэй ажиллаж биологийн шинжлэх ухааны молекул биологи, генетик, биотехнологи зэрэг салбаруудыг хөгжүүлэх, энэ чиглэлийн эрдэмтэд, судлаачдыг бэлтгэх, лабораториудын материаллаг баазыг бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн захирал Цэсрэнжавын Жанчивт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2002 оны 12 дугаар сарын 18-ны өдөр** **Дугаар 197** **Улаанбаатар хот**

**Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Уул уурхай, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээ, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Доёдын Алмаас -Нийслэлийн "Ямуха" ХХК-ийн "Ямуха" орчуулгын товчооны орчуулагч
2. Дэлгэрийн Баянмөнх -Батлан хамгаалах яамны дэргэдэх ахмад уран бүтээлчдийн "Дайчин алдар" чуулгын гоцлол дуучин
3. Дуламын Дашжамц -ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн дэд захирал
4. Борын Дашзэвэг -Батлан хамгаалах яамны дэргэдэх ахмад уран бүтээлчдийн "Дайчин алдар" чуулгын бүжигчин
5. Гүндсамбуугийн Сундуйжав -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн геологи хайгуулын ангийн дарга
6. Сийлэгийн Цогт-Очир -Нийслэлийн "Эрдэс холдинг" ХХК-ийн Их шарын голын алтны үйлдвэрийн дарга

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Доржийн Агий -Өмнөговь аймгийн Манлай сумын Өөхий багийн малчин
2. Данзан-Очирын Аваадорж -ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн газрын нөөц, газар ашиглалтын салбарын эрхлэгч
3. Цэрэндоржийн Авирмэд -Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Өтгөн багийн малчин
4. Нямын Аюуш -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга
5. Дэмчигийн Бадамгарав -ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан
6. Чулуунгомбын Базарсад -ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан
7. Лхамсүрэнгийн Батдэлгэр -Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сум дахь "Могойн гол" ХК-ийн гүйцэтгэх захирал
8. Тарзадын Батмөнх -Дархан-Уул аймгийн Дархан сум дахь үйлдвэрлэл, худалдааны "Монгол алт" ХК-ийн дэд захирал
9. Лувсанцэрэнгийн Бат-Өлзий -Хөвсгөл аймгийн Зураач, урчуудын холбооны зураач
10. Эрдэнэдалайн Батсайхан -Дархан-Уул аймаг дахь "Дархан-Нэхий" ХК-ийн гүйцэтгэх захирал
11. Эрдэнээгийн Батсүх -Дорноговь аймгийн Өргөн сум дахь Өргөний уулын үйлдвэрийн дарга
12. Нам-Осорын Батчулуун -Хөвсгөл аймгийн Мөрөн сумын барилга угсралт, засварын "Мөнх-Өргөө" ХХК-ийн захирал
13. Гарамжавын Баяраа -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн хүдрийн ил уурхайн тэсэлгээчин
14. Ашхүүгийн Баярсайхан -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "МВС групп" ХХК-ийн захирал
15. Аюурзаны Болд -ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн лабораторийн эрхлэгч
16. Осорын Бүрэнжаргал -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн ахмад ажилтан
17. Гунгаагийн Бэгз -Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "DHL" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч
18. Очирын Бямбаа -Баянхонгор аймгийн Баянхонгор сумын "Номун далай" цогцолбор сургуулийн биеийн тамирын багш
19. Надмидын Бямбадорж -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн хүдрийн ил уурхайн дарга
20. Сандагийн Бямбадорж -Дархан-Уул аймаг дахь Төмөрлөгийн үйлдвэрийн ерөнхий цахилгаанчин
21. Санжаагийн Ганжууржав -Дархан-Уул аймаг дахь Төмөрлөгийн үйлдвэрийн мэргэжилтэн
22. Лхажаагийн Ганхуяг -Увс аймгийн Цагаанхайрхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга

23. Дамбадаржаагийн Гомбодаш -Төв аймгийн Эрдэнэсант сумын 4 дүгээр багийн малчин
24. Дамбийн Готов -Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн дарга
25. Өвгөний Готовдорж -Эрдэс боловсруулалтын технологийн шинжилгээний төвийн засварчин
26. Бадарчийн Дааримаа -Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Мон Хүнс" ХХК-ийн захирал
27. Дүгэрийн Даваа -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Атар-Өргөө" ХК-ийн сантехникч
28. Хөтгөрийн Дагвадорж -Үйлдвэр, худалдааны яамны Ашигт малтмалын Хэрэг эрхлэх газрын мэргэжилтэн
29. Ганжууржавын Далхсүрэн -Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх орон нутгийн эмчийн албаны дарга
30. Үлэмжийн Дамиран -Увс аймгийн Тэс сумын 3 дугаар багийн Засаг дарга
31. Чимидийн Дамиран -Ховд аймгийн Булган сумын үйлдвэр, худалдааны "Жаргалант" ХХК-ийн зөвлөх
32. Банзрагчийн Дашдулам -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн чанар шалгагч
33. Жамбын Дашцэрэн -Бөхийн Их шавийн дээд сургуулийн дэд захирал
34. Санжаагийн Долгорсүрэн -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Тэмүүжин Мэнч" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч
35. Шажинбадрахын Дуламсүрэн -Нийслэлийн Баянзүрх дүүргийн 68 дугаар дунд сургуулийн бага ангийн багш
36. Чойжилжавын Дэчинпунцаг -ШУА-ийн Физик, технологийн хүрээлэнгийн автоматжуулалтын лабораторийн эрхлэгч
37. Адъяагийн Жамбал -ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч
38. Бэхчулууны Идэш -Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэлийн "Макс-Импекс" ХХК-ийн барилгын инженер
39. Лхамхүүгийн Лувсандорж -Хэнтий аймгийн Батноров сум дахь "Бэрх-Уул" ХК-ийн орлогч захирал
40. Лхан-Аажавын Мөнхбаяр -УБТЗ-ын ҮЭ-ийн холбооны дарга
41. Доржийн Нанзадсүрэн -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Атар-Өргөө" ХК-ийн нарийн боовчин
42. Цогбаатарын Нацаг -Улаанбаатар төмөр замын Сайншанд өртөөний дохиолол холбооны 3 дугаар ангийн холбооны механикч
43. Даваагийн Ома -Нийслэлийн "Капитрон" банкны дэд захирал
44. Дашдаваагийн Очирбат -Хөвсгөл аймгийн Зураач, урчуудын холбооны зураач
45. Тогтохын Оюунбазар -Зэвсэгт хүчний төв архивын дарга, хурандаа
46. Лувсандоржийн Өлзийбаяр -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Эрдэс холдинг" ХХК-ийн харьяа Их шарын голын алтны үйлдвэрийн инженер
47. Мандширын Пагма -Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Дэлгэрмөрөн" цогцолборын 1 дүгээр дунд сургуулийн гадаад хэлний багш
48. Агваанчүлтэмийн Пүрэв -ШУА-ийн Физик, технологийн хүрээлэнгийн лабораторийн эрхлэгч
49. Дамдинсүрэнгийн Пүрэвдорж -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн эдийн засагч
50. Гомбосүрэнгийн Пүрэв-Очир -Нийслэлийн Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн тасгийн дарга
51. Цэгмэдийн Пүрэвцэрэн -Нийслэлийн хайгуул, олборлолтын "Микмайнинг" ХХК-ийн Бугантын алтны уурхайн орлогч дарга
52. Жамцын Пэлжээ -Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн "ШУТМ төв" корпорацийн менежер
53. Гончигийн Сайнхишиг -ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
54. Лундэндоржийн Сандагдорж -Нийслэлийн зам гүүр, барилга засварын "Эрдэнэ зам" ХК-ийн инженер
55. Дамбийн Сарантуяа -Нийслэлийн 52 дугаар дунд сургуулийн химийн багш
56. Ламжавын Сольхүү -Завхан аймгийн Цагаанхайрхан сумын дунд сургуулийн бага ангийн багш
57. Нямжавын Сүхээ -Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
58. Борхүүгийн Сэнгэбаатар -Дорноговь аймгийн Иххэт сум дахь Хажуу-Улааны уулын үйлдвэрийн дарга
59. Санги-Оргийн Тогоо -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Т.Эм-Энд-Жи" ХХК-ийн захирал
60. Батсүхийн Төмөр -Хэнтий аймгийн Дархан сум дахь Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн жолооч
61. Банзрагчийн Тунгалаг -Үндэсний жүжгийн академик театрын филиал "Орчин үе" театрын дарга
62. Данзангийн Тэрбиш -Нийслэлийн Баянгол дүүргийн 66 дугаар цэцэрлэгийн багш

63. Ванчигийн Удвал -Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн

64. Дувсандандарын Хангай -Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга

65. Дугэрсүрэнгийн Хүүхэн -Өмнөговь аймгийн Ханбогд сумын Баян багийн малчин

66. Доржийн Цогбаатар -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газрын дарга

67. Батмөнхийн Цэгмид -Хэнтий аймгийн Дархан сум дахь Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн орлогч захирал

68. Бэрэнбаралын Цэдэнсодном -Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Бэрэн" ХХК-ийн зөвлөх

69. Бадарчийн Цэнд -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн авто тээврийн байгууллагын цахилгаанчин

70. Жамьяндоржийн Цэрэндорж -Үйлдвэр, худалдааны яамны Ашигт малтмалын Хэрэг эрхлэх газрын ахлах мэргэжилтэн

71. Аюурзаны Чимиддорж -Үйлдвэр, худалдааны улсын хяналтын албаны геологи, уул уурхайн хяналтын газрын дарга

72. Жамбалгаравын Чулуундорж -Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын ажилтан

73. Сампилын Шаравдорж -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн хэвлэл, мэдээллийн албаны дарга

74. Гомбожавын Шархүү -ШУА-ийн Физик, технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

75. Гүрсэдийн Энхбаяр -Нийслэлийн Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спорт сургалтын төвийн самбо, жудо бөхийн дасгалжуулагч

76. Дамбын Энхбаяр -ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн газар зүйн нэр судлал, зураг зүйн лабораторын эрхлэгч

77. Пүрэвийн Энхбаяр -Монгол-Оросын хамтарсан "Монголросцветмет" нэгдлийн ерөнхий захиралын орлогч

78. Аюушжавын Юмжээ -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Тэмүүжин-Мэнч" ХХК-ийн дэд захирал

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Мөнхийн Авирмэд -Дархан-Уул аймаг дахь Төмөрлөгийн үйлдвэрийн цехийн дарга

2. Хүрэнбандийн Адъяа -Дорноговь аймгийн Иххэт сум дахь Хажуу-Улааны уулын үйлдвэрийн гагнуурчин

3. Осорын Амгалан -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн геологи-хайгуулын ангийн өрөмдөгч

4. Батмөнхийн Атарсүрэн -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Зоос гоёл" ХК-ийн пааландагч

5. Сүрэнгийн Аюуш -Ховд аймгийн Үенч сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга

6. Доржийн Баатар Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга

7. Сүнрэвийн Бадам -Хэнтий аймгийн Батноров сум дахь "Бэрх-Уул" ХК-ийн механикч

8. Чойжинхүүгийн Балган -Нийслэлийн "Монмебель" ХК-ийн цахилгаанчин

9. Цэндийн Балжиддагва -Нийслэлийн зам гүүр, барилга засварын "Эрдэнэ зам" ХК-ийн жолооч

10. Банзрагчийн Батмандах -Дорнод аймгийн Стандартчилал, хэмжил зүйн төвийн улсын шалгагч

11. Гомбосүрэнгийн Бат-Өлзий -Хэнтий аймгийн Дархан сум дахь Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн нэвтрэгч

12. Чимэд-Очирын Батсандаг -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Микмайнинг" ХХК-ийн ерөнхий инженер

13. Чүлтэмийн Батсуурь -Дорноговь аймгийн Айраг сум дахь уулын үйлдвэрийн тэсэлгээний мастер

14. Агваанбалдангийн Баттулга -Хэнтий аймгийн Дархан сум дахь Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн жолооч

15. Чулууны Батцэнд -Увс аймгийн Хөгжимт драмын театрын гоцлол дуучин

16. Түвшингийн Батчулуун -Дорноговь аймгийн Айраг сум дахь уулын үйлдвэрийн хөдөлмөр хамгаалал аюулгүйн ажиллагааны инженер

17. Шархүүгийн Батчулуун -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн хүдрийн ил уурхайн өрмийн машинч

18. Данхүүгийн Баярсайхан -Хэнтий аймгийн Дархан сум дахь Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн баяжуулах фабрикийн дарга

19. Гэндэндамбын Бира -Булган аймгийн Төв номын сангийн фондчин

20. Жамбалын Болд -Дархан-Уул аймаг дахь Төмөрлөгийн үйлдвэрийн

| | |
|---|---|
| | цахилгааны инженер |
| 21. Шаравжамцын Болд | -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн дулаан агаар-жуулалтын албаны дарга |
| 22. Дагвын Болд-Эрдэнэ | -ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан |
| 23. Чагдагийн Бороохой | -Хөвсгөл аймгийн Арбулаг сумын 1 дүгээр багийн малчин |
| 24. Сономын Буд | -Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Мандал багийн малчин |
| 25. Балдандоржийн Буджаргал | -Монгол Оросын хамтарсан "Монголросцветмет" нэгдлийн барилгын удирдах газрын ерөнхий инженер |
| 26. Гомбосүрэнгийн Бямбасамбуу | -Нийслэлийн Баянгол дүүргийн өндөр настан, ахмад тээвэрчин |
| 27. Дашдэлэгийн Бямбасүрэн | -Дорноговь аймгийн Айраг сум дахь уулын үйлдвэрийн жолооч |
| 28. Мишигийн Бямбасүрэн | -Хэнтий аймгийн Батноров сум дахь "Бэрх Уул"ХК-ийн нэвтрэгч |
| 29. Сүрэнгийн Гаваа | -Нийслэлийн Архивын албаны дарга |
| 30. Уртнасангийн Галбадрах | -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Зоос гоёл " ХК-ийн өнгөлөгч |
| 31. Шагдарын Гонгорсүрэн | -Хөвсгөл аймгийн Рашаант сумын Засаг даргын Тамгын газрын бичээч, бичиг хэргийн эрхлэгч |
| 32. Гомбожавын Гүндсамбуу | -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул,уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн засварчин |
| 33. Дүрзээгийн Гүнсэл | -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн баяжуулагч |
| 34. Чоөнгийн Даваа | -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн засварчин |
| 35. Дамдинжавын Даваацям | -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Атар-Өргөө"ХК-ийн санхүү, эдийн засгийн албаны дарга |
| 36. Дамжингийн Дамба | -Нийслэлийн хайгуул олборлолтын "Микмайнинг" ХХК"-ийн гүйцэтгэх захирал |
| 37. Лойпилийн Дамба | -Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын дунд сургуулийн гадаад хэлний багш |
| 38. Лувсангийн Дарьсүрэн | -Зэвсэгт хүчний төв архивын архивч |
| 39. Жамъяншаравын Дуламсүрэн | -Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын бичээч |
| 40. Хайдавын Жалбаа | -ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан |
| 41. Чулууны Жаргалсайхан | -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Эрдэс холдинг" ХХК-ийн Буянт-Харморьтын алтны үйлдвэрийн ерөнхий инженер |
| 42. Очирбатын Зоригт | -Үйлдвэр , худалдааны яамны Ашигт малтмалын Хэрэг эрхлэх газрын мэргэжилтэн |
| 43. Тодын Иргэл | -Хэнтий аймгийн Дархан сум дахь Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн засварчин |
| 44. Аварзэдийн Ичинхорлоо | -Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн эрхлэгч |
| 45. Нигметийн Кадырбек | -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн эрчим хүчний цехийн үйлдвэр техникийн товчооны дарга |
| 46. Сандагаагийн Лхагважав | -Нийслэлийн Татварын газрын татвар хураалтын хэлтсийн дарга |
| 47. Баламжавын Лхагвасүрэн | -Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сум дахь "Могойн гол" ХК-ийн мастер |
| 48. Дагдангийн Лхагвасүрэн | -Хэнтий аймгийн Батноров сум дахь "Бэрх-Уул" ХК-ийн засварчин |
| 49. Гиваасны Лхагвацэрэн | -Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Шаргалжуут тосгоны дунд сургуулийн арга зүйч |
| 50. Түндэвийн Лхамгарав | -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн товчооны дарга |
| 51. Жамъянгийн Мандахбаяр | -ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан |
| 52. Сэрээнэнгийн Мижигсэнгээ | -Нийслэлийн зам гүүр барилга, засварын "Эрдэнэ зам"ХК-ийн инженер |
| 53. Самбуугийн Моондой | -Дорноговь аймгийн Иххэт сум дахь Хажуу-Улааны уулын үйлдвэрийн жолооч |
| 54. Дамдинжавын Мөнхжаргал | -МУЭ-ийн хорооны зураач |
| 55. Шанжийн Мөнхөө | -Нийслэлийн мебель үйлдвэрлэл, худалдааны "Монмебель" ХК-ийн цахилгааны инженер |
| 56. Чүлтэм-Осорын Нямсүрэн | -Хөвсгөл аймгийн Арбулаг сумын 3 дугаар багийн малчин |
| 57. Гордоогийн Отгон-Өлзий | -Хөвсгөл аймгийн Тариалан сумын дунд сургуулийн бага ангийн багш |
| 58. Гомбожавын Оюунбазар | -Дархан-Уул аймгийн "Оюу-Энхжин" ХХК-ийн ерөнхий захирал |
| 59. Нанзадын Оюунцэцэг | -Нийслэлийн Баянзүрх дүүргийн 68 дугаар дунд сургуулийн бага ангийн багш |

60. Гомбодоогийн Оюунчимэг -Нийслэлийн Хан-Уул дүүргийн 52 дугаар дунд сургуулийнгадаад хэлний багш

61. Шаравын Оюун-Эрдэнэ -"Монголэмимпекс" концерний харъяа Архангай аймаг дахь компанийн нягтлан бодогч

62. Ядамжавын Пүрвээ -Монгол-Оросын хамтарсан "Монголросцветмет" нэгдлийн хэлтсийн дарга

63. Одгийвын Пүрэвдаш -Нийслэлийн мебель, үйлдвэрлэл, худалдааны "Монмебель" ХК-ийн зүсмэлийн цехийн дарга

64. Балдандугарын Пүрэвсүрэн -Нийслэлийн Баянзүрх дүүргийн "Баянзүрх тохижилт" компанийн хүний нөөцийн асуудал хариуцсан менежер

65. Цэрэндолгорын Равдандорж -Өмнөговь аймгийн Ханбогд сумын Баян багийн малчин

66. Аюушийн Санжаа -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт"үйлдвэрийн гүүрэн краны машинч

67. Чагдагийн Содбаатар - Нийслэлийн Баянгол дүүргийн өндөр настан, ахмад тээвэрчин

68. Намжимын Содномрэнцэн - Нийслэлийн худалдаа, зуучлалын "Минерал инвест холдинг" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч

69. Гэндэнгийн Сономдорж - Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн авто тээврийн байгууллагын дарга

70. Цэсэмийн Сугар - ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

71. Шээрэвийн Сүхээ - Хэнтий аймгийн Батноров сум дахь "Бэрх -Уул" ХК-ийн хэтийн төлөв хариуцсан орлогч захирал

72. Сүхбаатарын Төмөрбаатар - Хэнтий аймгийн Дархан сум дахь Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн цахилгаанчин

73. Дашдэндэвийн Төмөрдаваа - Дорноговь аймгийн Айраг сум дахь уулын үйлдвэрийн жолооч

74. Шагдарсүрэнгийн Төрбат - Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул, уурхайн баяжуулах"Эрдэнэт" үйлдвэрийн цахилгааны цехийн телемеханикийн хэсгийн дарга

75. Аюушийн Түвдэндорж - Монгол-Оросын хамтарсан "Монголросцветмет" нэгдлийн мэргэжилтэн

76. Цэвээлмаагийн Тумэнжаргал -Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сум дахь "Могойн гол" ХК-ийн дизельчин

77. Дугарын Цацрал -Нийслэлийн Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга

78. Лодонгийн Цэнгэлмаа -Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 107 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

79. Баасандамбын Цэнд-Аюуш -Төв аймгийн Заамар сум дахь "Хайлааст"ХК-ийн гагнуурчин

80. Лууwваагийн Цэрэндолгор -Нийслэлийн худалдаа, үйлдчилгээний "Ач дэлгэрэх" ХХК-ийн захирал

81. Балдангийн Цэцэгээ -Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн нярав-сувилагч

82. Дэмбэрэлийн Цэцэгээ -Баянхонгор аймгийн Өлзийт сумын дунд сургуулийн дуу хөгжмийн багш

83. Лувсанпунцагийн Цэцгээ -Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 79 дугээр цэцэрлэгийн эрхлэгч

84. Санжаагийн Чанцалмаа -Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын дунд сургуулийн газар зүйн багш

85. Самдангийн Чулуунбаатар -Хэнтий аймгийн Батноров сум дахь "Бэрх-Уул" ХХК-ийн сантехникийн засварчин

86. Түдэвийн Шар -Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Бортээг багийн малчин

87. Дагвасамбуугийн Шаравжав -Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Туяа багийн малчин

88. Нацагдоржийн Шаркүү -ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

89. Чулууны Эрдэнэчимэг -Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүн байгууллагын асуудал эрхэлсэн товчооны дарга

## ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Аюушийн Мандах -Цагдаагийн ерөнхий газрын судалгаа, мэдээлэл-үнэлгээний төвийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч

2. Шагдарын Мягмаржав -Нийслэлийн Цагдаагийн газрын Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

3. Доржийн Эрдэнэбилэг -Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах байцаагч , цагдаагийн дэд хурандаа

4. Нацагийн Эрдэнэтөгс -Тагнуулын ерөнхий газрын Архив, бүртгэлийн албаны ажилтан , ахмад

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2002 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр** — **Дугаар 223** — **Улаанбаатар хот**

**Төсөл дэмжих тухай**

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Малын зарим архаг халдварт өвчинтэй тэмцэх төслийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсугай.

2. Малын зарим архаг халдварт өвчинтэй тэмцэх төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах, олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламжид хамруулан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж явц, үр дүнг жил бүрийн I улиралд Засгийн газарт мэдээлж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **Н.ЭНХБАЯР**

**Хүнс, хөдөө аж ахуйн сайд** **Д.НАСАНЖАРГАЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2002 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр** — **Дугаар 224** — **Улаанбаатар хот**

**Хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4, "Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөр"-ийн 4.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2002 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөр"-ийн 1 дүгээр хавсралтын 7 дугаар заалтын "Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах" гэснийг "Нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах" гэж өөрчилсүгэй.

2. "Багануурын дулааны станц" хувьцаат компанийн нийт хувьцааг нэг багц болгон нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **Н.ЭНХБАЯР**

**Санхүү, эдийн засгийн сайд** **Ч.УЛААН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2002 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр** — **Дугаар 226** — **Улаанбаатар хот**

**Дуудлагын худалдаагаар худалдах төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн жагсаалт батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3, 29 дүгээр зүйл, 30 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дуудлагын худалдаагаар худалдах төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг хавсралт ёсоор батласугай.

2. Хавсралтад дурдсан үл хөдлөх хөрөнгийн худалдагдах үнийн дүнгийн 10 хүртэл хувьд хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн баталгаажуулсан цэнхэр болон ягаан тасалбарыг төлбөрт тооцон авахыг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд зөвшөөрсүгэй.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **Н.ЭНХБАЯР**

**Санхүү, эдийн засгийн сайд** **Ч.УЛААН**

*Засгийн газрын 2002 оны 226 дугаар тогтоолын хавсралт*

## ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ТӨРИЙН ӨМЧИЙН ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| | Үл хөдлөх хөрөнгийн нэр | Байршил | Ашиглалтад орсон он | Нийт талбай ($м^2$) | Ашиглаж буй чиглэл | Түрээслэж буй болон эзэмшиж буй байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Төрийн өмчийн 8 дугаар байрны бүрэлдэхүүнд байгаа 10 хэсэг дан барилга (хуучнаар Барилгын техник мэргэжлийн сургуулийн дадлагын) | Улаанбаатар Баянгол дүүрэг, 17 дугаар хороо | 1960 | 1125.0 | Сургалтын төв, телевизор засвар, хүнсний дэлгүүр, баар, диско клуб, зурагчин, үйлчигээ | "Тэмүүлэн тех" ХХК, "Ширээ толгой" ХХК, "Т ба Д Трейд" ХХК, "Хүүгийн ач" ХХК, "Хойд ундарга" ХХК, "Ё эс Би" ХХК, "Абука" ХХК, "Монбар инженеринг" ХХК |
| 2. | Төр, Засгийн үйлчилгээний авто баазын зүүн хэсэг | Улаанбаатар Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо | 1960 | 2000.0 | Автомашины засвар үйлчилгээ | "Монголиан стар Мелшерс" ХХК |
| 3. | Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн 3 ширхэг дан барилга | Улаанбаатар Баянгол дүүрэг | 1951 | 630.0 | Эмийн сангийн үйлчилгээ | "Чандман-Эрдэнэ" ХЭАА, "Са-Эн-Илч" ХХК |
| 4. | "Дэлгэрхангай" хиамны цехийн өргөтгөлийн барилга | Улаанбаатар Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо | 1965 | 92.0 | Албан контор, ундааны цех | "Мончипс" ХХК |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.**
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003
Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
Хэвлэлийн хуудас 2
☎ 329487